



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/640.

Алтай хот

“Маскаа зүүцгээе-2” дугаар аяныг
өрнүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а” дахь заалт, 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8 дахь заалт, Аймгийн онцгой комиссын 11 дүгээр сарын 06-ны өдрийн 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, олон нийтийн дунд коронавирус (КОВИД-19) халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хандлага суларч, эрсдэл нэмэгдэж байгаа тул халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх ажлыг чангатгах зорилгоор “Маскаа зүүцгээе-2” аяныг өрнүүлэх, иргэдэд маск зүүж үйлчлүүлэхийг хэвшүүлэх, маск зүүгээгүй иргэдэд үйлчлүүлэхгүй байхыг өмчийн хэлбэр үл хамааран нийт аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгосугай.

2.Тус аяныг иргэдэд сурталчилах, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, ажлын удирдамжийг батлуулж, хэрэгжилтийг хангаж, хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг онцгой комисст танилцуулж ажиллахыг Онцгой байдлын газар (З.Баттулга), Эрүүл мэндийн газар (Ц.Туяа), Цагдаагийн газар (М.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга)-т тухайн сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Я.Эрхэмбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201001766